

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 09 дүгээр сарын 25

Замын-Үүд сум

Тус газар нь Монгол улс, Олон улсын хэлэлцээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Боомтын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145, 339, 146 дугаар тогтоол журам тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилэхэд анхаарч 2018 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз олгохыг хүссэн 9 орны 78 иргэнд зохих зориулалт ангиллын визийг олгож, визийн хураамж болох 5,032.200 төгрөг, визийн үнэ болох 412,200 төгрөгийг Төрийн сангийн зохих дансанд нь төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- Нэг удаагийн орох – 3 иргэн
- Нэг удаагийн гарах, орох – 44 иргэн
- Визийн шилжүүлэг – 6 иргэн
- Нэг удаагийн дамжин өнгөрөх – 2 иргэн
- Алдаатай олгосон виз засварлан – 23

1.2 Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар:

Боомт, орон нутгийн хэлтсийн даргын 2017.05.26-ны өдрийн 11/2092 тоотийг үндэслэн хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 1325 иргэн /давхардсан тоогоор/-ний хөдөлгөөнд, бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар:

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас алдаатай олгогдсон 5 орны 23 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1.4. Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

БНХАУ-ын 26 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч, мэдээллийг нь зохих хугацаанд Төвд хүргүүлж ажилласан.

1.5 Түр ирэгч бүртгэлийн талаар:

Түр ирэгчээр 5 орны 52 гадаадын иргэн бүртгэн, бүртгэлийн хураамж болох 104.0 мянган төгрөгийг зохих дансанд төвлөрүүлсэн.

1.6. Хасалт хийсэн талаар:

Насанд хүрээгүй тул торгуулиас чөлөөлөгдөн бүртгэлд хасалт хийлгэсэн 2 орны 10 иргэн, Зөрчил гарган, захиргааны шийтгэл ногдуулсан 5 орны 35 иргэн, Оршин суух зөвшөөрөлд уригчийн хүсэлтээр хасалт хийж, ОСЗ хураалгасан БНХАУ-ын 28 иргэн хасалт 45 иргэн, оршин суух зөвшөөрлийн хасалт 28 иргэн нийт 73 иргэнд хасалт хийж Монгол Улсаас гаргасан болно.

1.7. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6-ийн дагуу Монгол улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй 1 орны 7 иргэнийг улсын хилээр оруулалгүй буцаан ажилласан.

1.8. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 7 орны 45 иргэнийг 3,337.0 мянган төгрөг, 5 аж ахуйн нэгж байгууллагын 15 иргэнд 884,0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 1 удаагийн хяналт шалгалтыг Замын-Үүдийн Тагнуулын байгууллагатай хамтран зохион байгуулж 1 аж ахуйн нэгж байгууллагын 18 гадаадын иргэн, төлөвлөгөөт хяналт шалгалтаар 12 орны 304 гадаадын иргэн нийт 323 гадаадын иргэний паспорт паспортыг орлох баримт бичигт үзлэг шалгалт хийсэн.

Хууль тогтоомж зөрчсөн БНХАУ-ын 14 иргэнд зөрчлийн тухай хуулийн 16.2.1.4-д заасны дагуу 1,400.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, ГИЭЗБТх-ийн 37.1.7 дугаар зүйл болон Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журамын 3.7 дахь заалтад заасны дагуу МУ-д 3 жилийн хугацаанд дахин нэвтрэх эрхгүйгээр албадан гаргаж ажилласан болно.

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа гадаадын иргэдийн паспорт баримт бичиг, виз, оршин суух зөвшөөрөл, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй хөдөлмөр эрхэлж буй эсэхэд хяналт шалгалтыг аймгийн Тагнуулын тасгийн ажилтаны хамтаар хийж гүйцэтгэсэн. Хариуцдаг нутаг дэвсгэрийн нийт 14 аж ахуйн нэгж байгууллага 5 орны 58 иргэний паспорт баримт бичигт шалгалт хийж, нийт 208 км явж ажилласан. Шалгалтаар Говьсүмбэр аймгийн Баянтал сумын нутаг дэвсгэрт төмрийн хүдэр боловсруулах “Ган болд металл” ХХК дээр БНХАУ-ын 3 иргэнд Эрээн хотоос олгогдсон “В” ангиллын нэг удаагийн 30 хоногтой визээр 2018 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр Замын-үүд авто замын боомтоор орж ирэн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлж байсныг шалгалтаар илрүүлэн тайлбар авч, дүрс бичлэг, зурагжуулж бичиг баримтыг хураан Дорноговь аймаг дахь газарт шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн №05 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгэрээр хот хоорондын тээврийн хэрэгслээр зорчиж яваа гадаадын бичиг баримтанд хяналт шалгалт хийж ажиллалаа. Нийт 8 иргэний баримт бичигт шалгалт хийсэн байна. Шалгалтаар биз, оршин суух зөвшөөрөл холбоотой зөрчил болон Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэд илрээгүй.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд Дорноговь аймаг дахь газар үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээ, тус газрын сар бүрийн үйл ажиллагааны тайланг гаргаж Боомт, орон нутгийн газарт хэлтэст тус тус хүргүүлэн ажиллаж байна.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Дорноговь аймаг дахь газар нь албан хэрэг хөтлөлтийн ажилладаг “Хяналтын карт”, ирсэн бичиг, өргөдөл, гомдолд “Бүртгэл хяналтын карт”-ыг тухай бүр хөтөлдөг ба хариутай албан бичгийг стандартын дагуу боловсруулдаг болно.

Тайлант хугацаанд тус газрын бичиг хэрэгт 12 албан бичиг ирснийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 3 албан бичгийн хариуг өгч, 8 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Албан хаагчдаас чөлөө хүссэн 3 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн. Харин тус газарт ирсэн гомдол байхгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтад 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсонтой холбогдуулан ГИХГ-ын даргын энэ оны Б/51 дүгээр тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 28 бөгөөд бүртгэлтэй байгаа 25 албан хаагчаас 24 албан хаагч ажиллаж байна. Үүнээс хүүхэд асрах чөлөөтэй 1 албан хаагч байна.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар

Тайлант хугацаанд батлагдсан төсөв болох 37,746.1 мянган төгрөгийн санхүүжилт орсноор 55,359.0 мянган төгрөгний зарлага гаргасан. Үүнээс цалин хөлс 40,122.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 5,405.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 3,615.5 мянган төгрөгийг зарцуулан ажилласан.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр

Тайлант хугацаанд газрын хэмжээнд мэдээллийн технологийн ажлын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, албаны хэрэгцээнд ашиглагддаг нийт 15 компьютерийг форматлан хэрэглээний програм суулган “word” “excel” нь нэг стандартаар “Word 2013” хувилбарыг сонгон ашиглуулж байна. Мөн вирусийн програм тус бүр суулган сүлжээний аюулгүй байдлыг ханган ажилласан.

09-р сарын 11-ээс 13-ны өдрүүдэд тус газрын Ханги боомтод сүлжээ гацсан, “e-office” орохгүй байна гэсэн дуудлагын дагуу сүлжээний болон техник хэрэгслийн засвар үйлчилгээ хийсэн.

Мөн газрын даргын өрөөнд албаны камерыг телевиз дээр харах ажлыг хийж, нийт албан хаагчдын радио станц ашиглах, дуудах нэршлийн судалгааг гарган ажиллаж байна.

Гурав. Бусад

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газраас 14 хоногт нэг удаа зохиогддог аймгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд 2 удаа оролцсон.

Дотоод нөөц бололцоогоо ашиглан Төмөр замын боомтын албаны өрөөний тааз, хана, цонхны тавцан, гэрэлтүүлгийг шинээр сольж, Албан хаагчийн амьдарч буй 304, 309 тоот өрөөний тааз, ханыг замаскадаж, эмульдсэн мөн 2 давхрын коридорын цонхонд шинээр хөшиг суурьлуулж өнгө үзэмжийг сайжруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.


Төмөр замын боомтын албаны өрөөний засвар

Тааз, хана, цонхны тавцан, гэрэлтүүлгийг шинээр сольж сайжруулсан



Өмнө



Дараа



Албан хаагчийн амьдарч буй №304, №309 тоот өрөө



2 давхрын коридорын цонхонд шинээр хөшиг суулгав

